

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5	Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/334
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ахмад настны үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул Хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ахмад настны үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дугаар заалтын дагуу Ахмад настны үндэсний төв нь үйлчлүүлэгчдийн 2018 оны тэтгэврийн 30 хувь болох 121,123.9 мянган төгрөгийг Төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлэлгүйгээр бэлэн мөнгөний кассаар зарцуулсан, “Өгөөмөр баян булаг” ХХК-тай 2017 онд байгуулсан мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дүнгээс 43,215.4 мянган төгрөгийн бүтээгдэхүүн дутуу авсан боловч авлага үүсгээгүй эрх ба үүрэг үнэн зөв байх, хэмжигдэхүйц байх батламж мэдэгдэл болон Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Нийслэл аудит” ХХК-ийн Аудитор Б.Хөхөө, Д.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ахмад настны үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ахмад настны үндэсний төв нь үйлчлүүлэгчдийн эрхийг хүндлэн дээдэлж, сэргээн засах эмчилгээ сувилгаа үзүүлэх, тодорхой хөтөлбөрүүдэд хамруулан чадавхижуулах, хөгжүүлэх, цаашид удаан амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, аюулгүй орчноор хангахад оршино гэсэн эрхэм зорилготой ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ахмад настны үндэсний төв нь 1925 он “Өнчин ядуусыг тэтгэх газар” нэртэйгээр байгуулагдаж байсан улсын анхны асрамжийн төв юм. Тус оноос хойш Нийслэлийн хүрээнд 32 жил үйл ажиллагаа явуулж, 1957 онд Хэнтий аймгийн Цэнхэр мандал сум, 1967 онд төв аймгийн Батсүмбэр суманд шилжин суурьшсан байна.

Улсын асрамжийн газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 55 тоот тогтоолоор Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын харъяа “Ахмад настны үндэний төв” болон өөрчлөгдөж, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Төрөлжсөн асрамж
- Төрөлжсөн амралт
- Нөхөн сэргээх сувилал гэсэн бүтэцтэй, 3 алба, нийт 116 ажилтан, албан хаагчидтай ажиллаж байна

Ахмад настны үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ахмад настны үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Ахмад настны үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ахмад настны үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Ахмад настны үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ахмад настны үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгох нь зохимжтой гэж үзсэн бөгөөд улсын төсвийн орлогоос гадна хандив тусламжаар орлого төвлөрүүлдэгээс тэдгээрийг санхүүгийн тайланд тусгаагүй байх эрсдэл үүсэх магадлалтай гэж үзсэн болно.

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны нийт орлого 2,935,813.6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 58,716.27 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон бөгөөд аудитын гүйцэтгэлийн үе шатны явцад санхүүгийн тайлангийн орлогыг тайлагнахтай холбоотой эрсдэлүүд гараагүй болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож 5 асуудлыг алдаа зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулах асуудал гараагүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	/мянган төгрөгөөр/	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	164,339.3	
	Дүн	2	164,339.3	

2.8.13 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар хоол хүнсний бараа материал нийлүүлэх мөн үйлчлүүлэгсдийн тэтгэврийн 30 хувийн орлогыг хууль дүрэм, журмын дагуу төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушааж байгаа эсэхийг шалгаж үзэх болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ахмад настны үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой үндсэн болон туслах үйл ажиллагаанд зориулан 2018 онд 2,345,244.2 мянган төгрөгийн төсөв

батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,185,673.4 мянган төгрөг буюу 93.20 хувьтай байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Ахмад настны үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Ахмад настны үндэсний төв нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаа жил, улирал, сар тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Ахмад настны үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ахмад настны үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ахмад настны үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үйлчлүүлэгчийн тэтгэврийн 30 хувийн орлогын талаар

3.1.1 Илрүүлэлт:

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дугаар заалтын дагуу Ахмад настны үндэсний төвийн үйлчлүүлэгчдийн 2018 оны тэтгэврийн 30 хувийн орлого болох 121,123.9 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд тушаалгүйгээр бэлэн мөнгөний кассаар, зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 тоот тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмын 2 дугаар зүйлийн 6 дугаар заалт “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Орлогыг бууруулж санхүүгийн тайланд тусагснаас үр дүн буурч, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж, хэрэглэгчид болон удирдлагад буруу мэдээлэл өгч шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30 хувийн орлогыг хууль дүрэм, журмын дагуу төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушааж байх Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Тендерийн сонгон шалгаруулалтын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Ахмад настны үндэсний төв нь 2017 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу “Мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх АНҮТ-2017-НТШ-02 дугаартай нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр “Өгөөмөр баян булаг” ХХК шалгаран 247,275,3 мянган төгрөгийн гэрээ байгуулж төлбөрийг хэсэгчлэн шилжүүлжээ. Худалдан авалтын гэрээнд 33,050 кг 7 төрлийн мах махан бүтээгдэхүүнийг 1 кг-ыг дунджаар 7,481 төгрөг буюу нийт 247,275.3 мянган төгрөгөөр авахаар тохиролцож, гүйцэтгэлээр 27,273.9 кг махыг 204,059.7 мянган төгрөгөөр авсан байна. Үлдэгдэл 5,776.03 кг 43,215.4 мянган төгрөгийн махыг нийлүүлээгүй байхад тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д Жинхэнэ хэрэгжсэн байх 5.1.4-д Үнэн зөв байх, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, Хөрөнгө, бараа материал хяналтгүй зүй бусаар зарцуулагдаж, алдаа залилангийн эрсдэлтэй.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дутуу нийлүүлэгдсэн 43,215.4 мянган төгрөгийн мах махан бүтээгдэхүүний дүнгээр “Өгөөмөр баян булаг” ХХК-иас авлага үүсгэж бүртгэх. Цаашид заавар журмыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Цаашид дээр дурдсан зөрчлүүдийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>646,483,734.59</u>	<u>793,896,364.31</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	53,534,649.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	53,534,649.00	-
31110	Төгрөг	-	
31120	Гадаад валют		
31130	Нэмэлт санхүүжилт	53,534,649.00	-
31140	Касс арилжааны банк		
33	АВЛАГА	-	64,000,000.00
335	Бусад авлага	-	64,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага		64,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	592,949,085.59	729,896,364.31
351	Түүхий эд материал	20,120,068.01	25,438,179.84
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	20,120,068.01	25,438,179.84
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	479,423,407.58	608,002,574.47
35410	Бичиг хэргийн материал		593,250.00
35420	Аж ахуйн материал	227,495,382.00	253,012,296.69
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	3,385,307.00	
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	162,809,718.58	241,643,887.78
35470	Бусад хангамжийн материал	85,733,000.00	112,753,140.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	93,405,610.00	96,455,610.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,211,168,410.16</u>	<u>10,606,419,365.16</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
371	Урт хугацаат хадгаламж	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,211,168,410.16	10,606,419,365.16
391	Газар		
392	Биет хөрөнгө	10,210,590,910.20	10,606,034,365.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,656,718,255.00	10,391,914,798.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,120,759,595.24	-488,140,774.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,598,764.00	208,598,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-105,538,737.12	-139,105,587.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	641,659,473.20	775,769,153.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-120,974,759.82	-200,633,038.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,243,450.00	111,502,450.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,355,939.82	-53,871,399.30
393	Биет бус хөрөнгө	577,499.96	384,999.92
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-192,500.04	-385,000.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,857,652,144.75</u>	<u>11,400,315,729.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

42231	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10,857,652,144.75</u>	<u>11,400,315,729.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,857,652,144.75	11,400,315,729.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	870,065,632.00	870,065,632.00
51101	Өмч: - төрийн	870,065,632.00	870,065,632.00
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	9,503,649,322.75	9,725,324,258.43
51210	Өмнөх үеийн үр дүн	9,503,649,322.75	9,592,184,188.75
51220	Тайлант үеийн үр дүн		133,140,069.68
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	483,937,190.00	804,925,839.04
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10,857,652,144.75</u>	<u>11,400,315,729.47</u>

4.2 САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,527,774,355.27	2,935,813,648.25
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	855,010,755.27	1,139,366,748.25
120	Нийтлэг татварын бус орлого	855,010,755.27	1,139,366,748.25
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	854,260,755.27	1,139,366,748.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,016,179.00	686,244,840.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	501,244,576.27	453,121,908.25
120005	Түрээсийн орлого		
120006	Газрын тосны орлого		
120007	Навигацийн орлого		
120008	Монгол банкны ашиг		
120009	Бусад орлого	750,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,672,763,600.00	1,796,446,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,672,763,600.00	1,796,446,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,672,763,600.00	1,796,446,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,131,615,051.04	2,802,673,578.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,131,615,051.04	2,802,673,578.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,067,078,418.04	2,632,258,556.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	697,512,542.00	803,890,009.00
210101	Үндсэн цалин	650,087,145.00	672,007,319.00
210102	Нэмэгдэл	26,123,800.00	75,961,479.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,130,100.00	36,486,135.00
210104	Урамшуулал		-
210105	Гэрээт ажлын хөлс	7,171,497.00	19,435,076.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,185,202.93	96,529,596.15
210201	Тэтгэврийн даатгал	49,754,220.05	81,981,762.90
210202	Тэтгэмжийн даатгал	7,107,745.72	2,909,566.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,686,196.58	3,636,958.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,421,549.14	727,391.68
210205	Эрүүл мэндийн даатгал	14,215,491.44	7,273,916.42
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,855,210.00	265,091,644.48
210301	Гэрэл, цахилгаан	79,741,160.00	87,331,161.00

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	151,973,800.00	154,894,000.00
210303	Цэвэр, бохир ус	11,140,250.00	22,866,483.48
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	45,710,583.00	72,681,686.00
210401	Бичиг хэрэг	3,155,620.00	2,237,250.00
210402	Тээвэр, шатахуун	26,514,693.00	37,615,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	2,590,920.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,595,000.00	7,275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,945,270.00	22,963,366.00
2105	Нормативт зардал	576,486,506.33	874,617,813.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,912,557.51	57,339,343.94
210502	Хоол, хүнс	459,952,968.82	692,501,885.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	73,620,980.00	124,776,583.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,130,064.00	86,260,226.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	24,130,064.00	86,260,226.00
2107	Томилолт, зочны зардал	6,944,000.00	3,042,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	6,944,000.00	3,042,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,660,206.00	5,897,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	2,475,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	471,406.00	739,457.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	516,500.00	483,333.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	692,300.00	304,570.00
210807	Газрын төлбөр	3,480,000.00	1,895,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	388,594,103.78	424,248,222.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,325,030.00	103,960,789.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	283,269,073.78	320,287,433.04
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,536,633.00	170,415,021.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,965,000.00	4,986,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		4,986,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,965,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,571,633.00	165,429,021.85
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,571,633.00	165,429,021.85
213504	Хөрөнгийн		
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>396,159,304.23</u>	<u>133,140,069.68</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>396,159,304.23</u>	<u>133,140,069.68</u>

4.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,026,529,779.00</u>	<u>2,482,691,740.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	353,766,179.00	686,244,840.00
120	Нийтлэг татварын бус орлого	353,766,179.00	686,244,840.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	353,766,179.00	686,244,840.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,766,179.00	686,244,840.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,672,763,600.00	1,796,446,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,672,763,600.00	1,796,446,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,672,763,600.00	1,796,446,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,963,625,109.00</u>	<u>2,484,877,589.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,963,625,109.00	2,484,877,589.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,899,088,476.00	2,250,462,567.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	697,512,542.00	803,890,009.00
210101	Үндсэн цалин	650,087,145.00	672,007,319.00
210102	Нэмэгдэл	26,123,800.00	75,961,479.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,130,100.00	36,486,135.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	7,171,497.00	19,435,076.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,542,195.00	96,529,596.15
210201	Тэтгэврийн даатгал	48,072,305.91	81,981,762.49
210202	Тэтгэмжийн даатгал	6,867,472.27	2,909,566.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,493,977.82	3,636,958.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,373,494.45	727,391.68
210205	Эрүүл мэндийн даатгал	13,734,944.55	7,273,916.83
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,881,410.00	262,955,161.00
210301	Гэрэл, цахилгаан	79,741,160.00	87,331,161.00
210302	Түлш, халаалт	149,000,000.00	154,894,000.00
210303	Цэвэр, бохир ус	11,140,250.00	20,730,000.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	57,177,030.00	64,853,390.00

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	2,712,800.00	2,395,800.00
210402	Тээвэр, шатахуун	29,900,000.00	37,375,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	2,590,920.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,595,000.00	7,275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,469,230.00	15,215,820.00
2105	Нормативт зардал	714,665,839.00	844,212,852.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,713,979.00	51,787,732.00
210502	Хоол, хүнс	546,333,860.00	669,838,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	129,618,000.00	122,586,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,030,224.00	59,692,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	11,030,224.00	59,692,410.00
2107	Томилолт, зочны зардал	6,944,000.00	3,042,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	6,944,000.00	3,042,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,660,206.00	6,357,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	2,475,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	471,406.00	739,457.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	516,500.00	483,333.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	692,300.00	764,570.00
210807	Газрын төлбөр	3,480,000.00	1,895,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,675,030.00	108,929,789.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,675,030.00	108,929,789.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,536,633.00	234,415,021.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,965,000.00	4,986,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		4,986,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,965,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, илжүүлэг	29,571,633.00	229,429,021.85
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,571,633.00	229,429,021.85
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>62,904,670.00</u>	<u>-2,185,849.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,370,021.00	51,348,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,370,021.00	51,348,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,370,021.00	51,348,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,370,021.00	51,348,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-9,370,021.00</u>	<u>-51,348,800.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	53,534,649.00	-53,534,649.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		53,534,649.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,534,649.00	-

4.4 ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,107,490,018.52	10,461,492,840.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,107,490,018.52	10,461,492,840.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			396,159,304.23	396,159,304.23
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,503,649,322.75	10,857,652,144.75
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,503,649,322.75	10,857,652,144.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			88,534,866.00	88,534,866.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,592,184,188.75	10,946,187,010.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		320,988,649.04		320,988,649.04
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			133,140,069.68	133,140,069.68
2018 оны 12 -р сарын 31-нээрх үлдэгдэл	870,065,632.00	804,925,839.04	9,725,324,258.43	11,400,315,729.47

4.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,345,244,200.00	2,185,673,378.15	159,570,821.85	93.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,345,244,200.00	2,185,673,378.15	159,570,821.85	93.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,340,258,200.00	2,180,687,378.15	159,570,821.85	93.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	868,350,300.00	803,890,009.00	64,460,291.00	92.58
210101	Үндсэн цалин	714,897,400.00	672,007,319.00	42,890,081.00	94.00
210102	Нэмэгдэл	84,557,400.00	75,961,479.00	8,595,921.00	89.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,256,300.00	36,486,135.00	13,770,165.00	72.60
210104	Урамшуулал			-	
210105	Гэрээт ажлын хөлс	18,639,200.00	19,435,076.00	-795,876.00	104.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,202,000.00	96,529,596.15	7,672,403.85	92.64
210201	Тэтгэврийн даатгал	68,619,100.00	81,981,762.49	-13,362,662.49	119.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,895,700.00	2,909,566.73	5,986,133.27	32.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,116,500.00	3,636,958.42	3,479,541.58	51.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,779,200.00	727,391.68	1,051,808.32	40.88
210205	Эрүүл мэндийн даатгал	17,791,500.00	7,273,916.83	10,517,583.17	40.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,829,000.00	262,955,161.00	13,873,839.00	94.99
210301	Гэрэл, цахилгаан	100,684,000.00	87,331,161.00	13,352,839.00	86.74
210302	Түлш, халаалт	154,894,000.00	154,894,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	21,251,000.00	20,730,000.00	521,000.00	97.55
210304	Байрны түрээс			-	
2104	Хангамж, бараа материалын зардал	84,710,600.00	65,803,390.00	18,907,210.00	77.68
210401	Бичиг хэрэг	3,237,500.00	2,395,800.00	841,700.00	74.00
210402	Тээвэр, шатахуун	42,137,200.00	37,375,850.00	4,761,350.00	88.70
210403	Шуудан, холбоо,интернэтийнтөлбөр	6,666,200.00	2,590,920.00	4,075,280.00	38.87
210404	Ном, хэвлэл	-	-	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,768,000.00	7,275,000.00	8,493,000.00	46.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,901,700.00	16,165,820.00	735,880.00	95.65
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
2105	Нормативт зардал	920,079,000.00	873,442,852.00	46,636,148.00	94.93

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,084,500.00	55,537,732.00	7,546,768.00	88.04
210502	Хоол, хүнс	710,624,500.00	695,318,720.00	15,305,780.00	97.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	146,370,000.00	122,586,400.00	23,783,600.00	83.75
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,276,800.00	68,240,410.00	1,036,390.00	98.50
210601	Багаж, техник, хэрэгсэл			-	
210602	Тавилга			-	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			-	
210604	Урсгал засвар	69,276,800.00	68,240,410.00	1,036,390.00	98.50
2107	Томилолт, зочны зардал	8,307,400.00	3,042,000.00	5,265,400.00	36.62
210701	Гадаад албан томилолт			-	
210702	Дотоод албан томилолт	8,307,400.00	3,042,000.00	5,265,400.00	36.62
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,800,500.00	6,577,360.00	1,223,140.00	84.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			-	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,475,000.00	2,475,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,227,500.00	739,457.00	488,043.00	60.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,178,000.00	483,333.00	694,667.00	41.03
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			-	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	984,570.00	5,430.00	99.45
210807	Газрын төлбөр	1,930,000.00	1,895,000.00	35,000.00	98.19
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	702,600.00	206,600.00	496,000.00	29.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	702,600.00	206,600.00	496,000.00	29.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,986,000.00	4,986,000.00	-	100.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			-	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг			-	

Ахмад настны үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	4,986,000.00	4,986,000.00	-	100.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	4,986,000.00	-	100.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,345,244,200.00	2,185,673,378.15	159,570,821.85	93.20	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,796,446,900.00	1,631,017,878.15	165,429,021.85	90.79	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,796,446,900.00	1,631,017,878.15	165,429,021.85	90.79	
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих			-		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	548,797,300.00	554,655,500.00	-5,858,200.00	101.07	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	548,797,300.00	554,655,500.00	-5,858,200.00	101.07	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	53,534,649.00	- 53,534,649.00	101.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		53,534,649.00	-53,534,649.00	101.07	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.25	Аудитын нэр: Ахмад настны үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код: САГ-2019/297/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ахмад настны үндэсний төв	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Үйлчлүүлэгчдийн тэтгэвэрийн 30 хувийн орлогын талаар	121.1	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Нэргүй
2	Тендерийн сонгон шалгаруулалтын талаар	43.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Нэргүй
	Дүн	164.3			

